



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 13

Мандалговь

Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх  
таван жилийн үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.2 е, 19 дүгээр зүйлийн 19.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн 6.7.2, 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсгийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг."Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг нэгдүгээр хавсралтаар, Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний болон техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт бүхий Дундговь аймгийн 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Дундговь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн жилийн аймгийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д даалгасугай

Гурав.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ



## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас 2020 онд батлан гаргасан “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулинд дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна гэж заасны дагуу Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл төлөвлөгөөг 2020 онд Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020 онд Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл төлөвлөгөө, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт”, салбарын хөгжлийн зорилтот хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан боловсруулсан болно.

Энэхүү бодлогын баримт бичиг нь 8 зорилгын хүрээнд 36 агуулгаар дэд зорилго дэвшүүлж, 51 зорилтыг хэрэгжүүлэх 199 арга хэмжээг төлөвлөн гаргалаа. Уг төлөвлөлтийг Канад улсын МЕРИТ төслийн шугамаар Удирдлагын академийн багшаас зөвлөгөө авч хянуулсан бөгөөд Үндэсний хөгжлийн газрын санал зөвлөмж, иргэд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөөс саналыг авч дахин сайжруулалт хийн хүргүүлж байна. Мөн 2020 оны 12 дугаар 07-ны өдөр УИХ, Засгийн газраас зохион байгуулсан цахим сургалтаар өгсөн чиглэлийг мөрдлөг болголоо. Үндэсний хөгжлийн газраас 3, иргэдээс 53 санал, ИТХ-ын төлөөлөгчдөөс 100 санал, тэргүүлэгчдийн 17 санал, мөн аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөөс гарсан 18 санал, нийт 191 санал ирсэн байна. Эдгээр саналуудыг багцлан авч үзсэнээс гадна нэг жилийн хугацаанд хэрэгжээд дуусах ажлыг жилийн төлөвлөгөөнд, хөрөнгө оруулалтын шинж чанартай жагсаалт ирүүлснийг боломжит хувилбараар бүлгүүдэд ерөнхий байдлаар орууллаа.

Бодлогын төслийг боловсруулахад дараах эх үүсвэрүүдээс судалгаа, тооцооллыг хийсэн болно. Үүнд:

1. Статистик мэдээлэл

2. Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт /аймгийн ИТХ-ын 2020 оны 01 дугаар тогтоол/

3. Дундговь аймгийн хөгжлийн бодлого стратеги 2012-2031 он хүртэлх бодлогын бичиг баримт /аймгийн ИТХ-ын 2012 оны 01 дугаар тогтоол/

4. Говийн дэд бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр /судалгааны тайлангууд, МУИС-ийн эдийн засгийн хүрээлэн/

#### АЙМГИЙН ХӨГЖИЛД ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн дэвшүүлсэн зорилго зорилтууд биелсэнээр Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн эдийн засгийн хүрээнд ДНБ-ийг 383383,01 сая төгрөг байгааг 545572,9 сая төгрөгт хүргэх, Амьдралын чанар, дундаж давхрагын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг 2 хувиар нэмэгдүүлэх, хүний хөгжлийн хүрээнд дундаж наслалтыг 75,0-д хүргэх, ногоон хөгжлийн хүрээнд ногоон байгууламжийг 396,4 га байгааг 414,4 га-д хүргэх, бүс, орон нутгийн хөгжлийн хүрээнд аялал жуулчлал, ХАА-г байгальд ээлтэй, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгох зэрэгт үр нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

## АГУУЛГА

НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ

ТАВ. ЗАСАГЛАЛ

ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ

ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УТХО - УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ  
ОНТ – ОРОН НУТГИЙН ТӨСӨВ  
АЗДТГ – АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
ТЗУХ – ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС  
ХЭЗХ – ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС  
НБХ – НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС  
ХОХБТХ – ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС  
СТСХ – САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС  
ААН – АЖ АХУЙН НЭГЖ  
ЦГ- ЦАГДААГИЙН ГАЗАР  
БСУГ- БОЛОВСРОЛ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР  
НД – НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС  
ХХҮҮГ- ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР  
ХХААГ- ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР  
БОАЖГ- БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР  
ЭМГ- ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР  
ОБГ- ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР  
ГХБХБГ- ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР  
ГБХЗХГ- ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР  
МЭГ- МАЛ ЭМНЭЛЭГИЙН ГАЗАР  
ШША – ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА  
УЦУОШТ – УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
СУБ – СОЁЛ УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГА  
ТХДЖТ – ТӨВ ХАЛХЫН ДУУЛАЛТ ЖҮЖГИЙН ТЕАТР  
ТТХТ – ТЭНГЭРИЙН ТЭМДЭГ ХҮҮХДИЙН ТЕАТР  
МСҮТ – МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ  
БТСГ – БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР  
ГХУСАЗЗ-ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЙМГИЙН ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛ  
ОНӨҮГ – ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР  
БЗӨБЦТС - БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ  
ТӨХК – ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ЦТСС – ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ САЛБАР  
ШҮГ – ШУУДАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР  
ОУБ – ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА  
ЭТИС - ЭРДЭС БАЯЛАГ ТҮҮХИЙ ЭДИЙН ИЖ БҮРЭН САНААЧЛАГА  
ЭМДТ- ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАСАГ  
ЦШ-ЦЭРГИЙН ШТАБ

# ДУНДГОВЬ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

## НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

**Зорилго 1. Аймгийн ДНБ-д соёл урлагийн салбарын эзлэх хувь 2019 онд 0.61 хувь байсныг 2025 онд 0.81 хувьд хүргэнэ.**

### **Үндэсний бахархал, эв нэгдэл**

Зорилго 1.1 Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх оронч үзэл хандлагыг төлөвшүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэд 2019 онд 294454 байгааг 2025 онд 46400-аар нэмэгдүүлнэ.

**Зорилт 1.1.1 2020 онд соёл урлагийн салбарт насжилт өндөртэй барилга байгууламж 14 байгааг 2025 онд 85,7 хувийг нь шинэчилж, чанартай тоног төхөөрөмжөөр хангана.**

1.1.1.1 Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилга барьж, ашиглалтад оруулна.

1.1.1.2 Аймгийн Музейн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.

1.1.1.3 Хүүхдийн театрын шинэ барилга барьж, ашиглалтад оруулна.

1.1.1.4 Сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, Цагаандэлгэр, Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Баянжаргалан, Өндөршил, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрхангай сумдын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.

1.1.1.5 Аймгийн Төв Номын сангийн барилгын дээврийн засвар, Сайхан-Овоо сумын Соёлын төвийн барилгад их засвар хийнэ.

1.1.1.6 Соёл, урлагийн байгууллагуудын хөгжим, тоног төхөөрөмж, гэрэл, дууны техник хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлнэ.

**Зорилт 1.1.2 Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 2020 онд 60 байгааг 2025 онд 78.8 хувьд хүргэнэ.**

1.1.2.1 Соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, орон тоог нэмэгдүүлэн, салбарын ажилтнуудыг гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлнэ.

1.1.2.2 Соёл, урлагийн салбарын ажилтнуудыг орон сууцжуулна.

**Зорилт 1.1.3 Монгол зан заншил, өв соёлоо дээдэлсэн эв нэгдэл, эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээнд хамрагдагсадыг 2020 онд 986 байгааг 2025 онд 6500-д хүргэнэ.**

1.1.3.1 Сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрээт хамгаалагчтай болгоно.

1.1.3.2 "Бүрдийн уянга" хүүхдийн зусланг түшиглэн "Ардын зан үйл-амьдрах арга ухаан" хөтөлбөрт сургалтыг зохион байгуулна.

1.1.3.3 Хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэх "Ирээдүйн соёлтой үйлчлүүлэгч" төслийг сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж, Монгол өв соёл, ардын уламжлалт урлагаа сурталчлан таниулна.

1.1.3.4 "Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрын үйл ажиллагааг өргөжүүлэн, "Дуу хуурын өлгий" нутгийн залгамж халааг бэлтгэнэ.

### **Нүүдлийн соёл иргэншилт Монгол**

Зорилго 1.2 Нүүдэлчдийн өв соёл, ёс заншлыг түгээн дэлгэрүүлж, бүх нийтийн урлагын боловсролыг дээшлүүлэх замаар дүү хүүр брөндийг өвлүүлэн хөгжүүлэх соёл урлагийн арга хэмжээ 2019 онд 1431 байсныг 2025 онд 2876-д хүргэнэ.

**Зорилт 1.2.1 Монгол үндэсний өв соёлыг орон нутгийнхаа онцлогт нийцүүлэн туурвисан шинэ уран бүтээл 2020 онд 7 байсныг 2025 онд 2 дахин нэмэгдүүлнэ.**

1.2.1.1 Аймгийн Засаг даргын дэргэд "Мэргэжлийн соёл, урлагийн зөвлөл" байгуулан, соёл, урлагийн салбарын бодлого, үйл ажиллагааг чиглүүлнэ.

1.2.1.2 "Уяхан замбуу тивийн наран" уртын дуучид, морин хуурчдын эвент наадмыг зохион байгуулна.

1.2.1.3 Музейн сан хөмрөгийг насжилт өндөртэй эртний үзмэрүүдээр баяжуулан, нүүдлийн өв соёлыг сурталчилна.

1.2.1.4 Дуу хуурын өлгий нутгийн алдартан, гавьяатнуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан, алдаршуулна.

1.2.1.5 Дуу хуурын өлгий Дундговь аймгийн түүхэн онцлог ёс заншил, зан үйл, өв уламжлал болон түүх, соёлын дурсгалуудыг баримтат болон уран сайхны кинонд буулган, нүүдэлчин Монголчуудын өв соёлыг харуулсан баримтат өвийг бий болгоно.

1.2.1.6 Аймгийн гар урчуудын бүтээлээр үзэсгэлэн-худалдаа зохион байгуулж, дэг сургууль, арга барилыг нь өвлүүлнэ.

### **Монгол бичиг**

Зорилго 1.3 Дүндговьчуудын Үндэсний монгол хэл, бичгийн боловсрол эзэмшсэн байдал 2020 оны байдлаар 4782 байгааг 2025 онд 6692 -д хүргэж, хос бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

**Зорилт 1.3.1 Төрийн албан хаагчдын Монгол бичгийн хэрэглээг 2020 онд 10 хувьтай байгааг 2025 онд 100 хувьд хүргэнэ.**

1.3.1.1 Албан байгууллага, аж ахуй нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, нэрийн хуудас, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг монгол бичгээр бичиж хэвшүүлнэ

1.3.1.2 Төрийн албан хаагчдын модуль сургалтын кредитийг тооцон урамшуулал олгоно

1.3.1.3 "Улсын монгол бичгийн олимпиад"-ыг аймагт зохион байгуулна

1.3.1.4 "Үндэсний бичиг" олон талт арга хэмжээг зохион байгуулна

### **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ**

**Зорилго 2.** Нийгмийн суурь үйлчилгээг хүртээмжтэй хүргэж хүний хөгжлийн индексийн үзүүлэлтийг 2019 онд 0.689 байгааг 2025 онд 0.709 болгож өсгөнө.

### **Боловсрол**

Зорилго 2.1 Сургалтын чанарын үнэлгээний дундажийг 2019 онд 39.1 хувь байсныг 2025 онд 50 хувьд хүргэнэ.

**Зорилт 2.1.1 Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2020 онд 72.5 хувь байсныг 2025 онд 77 хувьд хүргэнэ.**

2.1.1.1 Шаардлагатай сумдын цэцэрлэгийн барилгыг барина.

2.1.1.2 1-2 настай хүүхдийг яслийн бүлэгт, 2-3 настай хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд хамруулна.

2.1.1.3 Цэцэрлэгийн бүлгийн багш нарыг хөгжим тоглох ур чадварт сургана.

2.1.1.4 СӨБ-ын урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

**Зорилт 2.1.2 ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалтын хувийг 2020 онд 91.6 байсныг 2024 онд 97.5 хүргэнэ**

2.1.2.1 Шаардлагатай сумдын сургууль, дотуур байрын барилгыг барина.



2.1.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролд хамран сургалтыг нэмэгдүүлж, бага ангийн багш нарын 70-аас доошгүй хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцуулна.

2.1.2.3 Гадаад хэл болон байгалийн ухааны судлагдахууны багш нарыг гадаад оронд мэргэжил дээшлүүлнэ

2.1.2.4 Улс, аймгийн туршлагатай багш нарыг түшиглэн сургалт, чансаа тогтоох сорилуудыг зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноог ахиулна

2.1.2.5 Чадварлаг багш цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ

2.1.2.6 Аймгийн Насан туршийн төв, сумдын насан туршийн нэгжүүдээр дамжуулан 9-12-р ангийн суралцагчид болон иргэд, эцэг эхчүүдэд амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, насан туршдаа суралцахуйн чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулна.

2.1.2.7 Сургууль бүрт байгалийн ухааны хичээлийн кабинет байгуулна.

2.1.2.8 Сургууль, цэцэрлэг, дотуур байрыг 100 хувь шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, дотор ОО-той болгоно.

2.1.2.9 Цэцэрлэг, сургууль, дотуур байрын гадаад дотоод орчныг бүрэн камержуулна.

**Зорилт 2.1.3 Бүх нийтийн урлагийн боловсролыг дээшлүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, дуу хуурын өлгий нутгийн брендийг өвлүүлэн хадгална.**

2.1.3.1 Ерөнхий боловсролын сургуульд "Хөгжмийн төрөлжсөн анги" байгуулна.

**Зорилт 2.1.4 МСҮТ-ийг магадлан итгэмжлэгдсэн Политехник коллеж болгож, төгсөгчдийн ажил эрхлэлт 2020 онд 65 байсныг 2025 онд 71 хувьд хүргэнэ.**

2.1.4.1 Байгууллагын магадлан итгэмжлэлд орно.

2.1.4.2 Багшлах бүрэлдэхүүний боловсролын зэргийг ахиулан магистрын сургалтад хамруулна.

2.1.4.3 Техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийг барилга болон хөдөө аж ахуйн мэргэжлийн чиглэлээр боловсруулж, дүгнэлт гаргуулна.

2.1.4.4 Хөдөө аж ахуйн мэргэжлийн кабинетыг байгуулна.

## **Эрүүл мэнд**

Зорилго 2.2 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж хүн амын дундаж наслалт 2019 онд 74.03 байсныг 2025 онд 75,0-д хүргэнэ.

**Зорилт 2.2.1 Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтийг 2019 онд 57.8 байсныг 2025 он гэхэд 69.8 хувьд хүргэнэ.**

2.2.1.1 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”. “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын тоог нэмэгдүүлнэ.

2.2.1.2 Орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулна.

2.2.1.3 Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулна.

**Зорилт 2.2.2 Эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлтийг 2020 онд 91.5 хувь байсныг 2025 онд 2.0 хувиар нэмэгдүүлнэ.**

2.2.2.1 Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг хэрэгжүүлнэ.

2.2.2.2 Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног, төхөөрөмжөөр тоноглоно.

2.2.2.3 Нэгдсэн эмнэлгийг компьютер томографи болон коронавируст халдвар/covid-19/-ын оношилгооны PCR шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангана.

2.2.2.4 Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг анхан шатны эмнэлгүүдэд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн компьютерээр хангана.

2.2.2.5 Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтын цахим тогтолцоог бүрдүүлж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлж, эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны зохицуулалтын эрх зүйн орчныг шийдвэрлэнэ.

**Зорилт 2.2.3 Хүний нөөцийн хангалтыг 2020 онд 96.7 хувь байсныг 2025 он гэхэд 98.1 хувьд хүргэж, нийгмийн хамгааллыг сайжруулна.**

2.2.3.1 Эмч, эмнэлгийн ажилчдын орон сууцыг нэмэгдүүлж салбарын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлнэ.

2.2.3.2 Эмч, эмнэлэгийн ажилтнуудыг гадаад, дотоодод сургаж, анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн эмч нарыг дотор, хүүхдийн нарийн мэргэшлээр сурган чадавхжуулж, орон нутагт нэн шаардлагатай сувилагч мэргэжилтнийг бэлтгэж хангалтыг нэмэгдүүлнэ.

## **Гэр бүл**

Зорилго 2.3 Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хөгжил, хамгааллыг сайжруулна.

**Зорилт 2.3.1 Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар гэрлэснээс тогтвортой байгаа бүлийн хувийг 2019 онд 98.5 байгааг 2025 онд 98.8 хувьд хүргэж нэмэгдүүлнэ.**

2.3.1.1 Гэр бүлийн боловсрол олгох сургалт, зөвлөгөөг зохион байгуулна

2.3.1.2 Түр хамгаалах жишиг байр бий болгоно.

2.3.1.3 Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг стандартын өрөөтэй болгож, хосуудын гэрлэх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулна.

2.3.1.4 Жендерийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд ТББ-аар жил бүр хяналт шинэжилгээ үнэлгээ хийлгэнэ.

2.3.1.5 Төрийн албан хаагчдын жендерийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох сургалт зохион байгуулна.

## **Хүнд ээлтэй амьдрах орчин**

Зорилго 2.4 Аймгийн ДНБ 2019 онд 383383.01 сая төгрөг байгааг 2025 онд 545572.9 сая төгрөгт хүргэнэ.

**Зорилт 2.4.1 Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлнэ**

2.4.1.1 Нийтийн хоол үйлдвэрлэлийн хоолны шим тэжээл, чанар, түүнд тавих хяналтыг сайжруулах, зэрэглэл өндөртэй үйлчилгээний байгууллагын тоог нэмэгдүүлнэ.

2.4.1.2 Аймгийн төвийн 6.4 км үерийн хамгаалалтын далангийн барилга, байгууламжийн угсралтын ажлыг үргэлжлүүлж, дуусгана.

## **Хөдөлмөрийн зах зээл**

Зорилго 2.5 Ажилгүйдлийн түвшинг 0.3 хувиар бууруулна.

### **Зорилт 2.5.1 Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг иргэн, ААНБ-ыг тогтмол авах боломжийг бүрдүүлнэ**

2.5.1.1 Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн санд бүртгэлтэй ажилгүй иргэдийг тохирох ажлын байранд зуучилна.

2.5.1.2 ААНБ-дад хөдөлмөрийн харилцааны сургалт зохион байгуулж, бүртгэлжүүлнэ.

2.5.1.3 Цалин хөлсний үзлэг зохион байгуулна.

### **Монгол хүний удмын сан**

Зорилго 2.6 2020 онд аймгийн нийт өрхийн 38.1 хувь нь угийн бичиг хөтөлснийг 2025 онд 30 хувиар нэмэгдүүлнэ.

**Зорилт 2.6.1 Угийн бичгийн сургалтад 2020 онд 8149 иргэн хамруулсныг 2025 онд 13149-т хүргэнэ.**

2.6.1.1 Угийн бичиг хөтлөлтийн ажлын үр дүнг тусгай болзол, журмын дагуу дүгнэнэ.

2.6.1.2 Угийн бичгийн тайлант үзэсгэлэн зохион байгуулна.

### **Шинэ сэргэж буй халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ**

Зорилго 2.7 **Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлнэ.**

**Зорилт 2.7.1 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу арга хэмжээний /тоног, төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл нөөц/ бэлэн байдлыг хангана**

2.7.1.1 Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангалтыг 2019 онд 80.0 хувь байсныг 2024 онд 90.0 хувьд хүргэнэ.

2.7.1.2 Нэгдсэн эмнэлгийг коронавируст халдвар/covid-19/-ын оношилгооны PCR шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангана.

### **ГУРАВ.АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА**

**Зорилго. 3 Хүний хөгжлийг дэмжин иргэдийн ажилтай орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэн, хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.03 хувиар нэмэгдүүлнэ.**

## Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл

Зорилго 3.1 Нийгмийн даатгалын хамрагдалтыг 2020 онд эдийн засгийн идэвхтэй хүн амын 52.4 хувь байсныг 2025 онд 60 хувь болгоно.

**Зорилт 3.1.1 Хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг 2020 онд 11198 байсныг 2025 онд 12218-д хүргэнэ.**

3.1.1.1 Иргэдэд үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

3.1.1.2 Нийгмийн даатгалын цахим үйлчилгээгээр үйлчлүүлэх иргэдийн хувийг нэмэгдүүлнэ.

**Зорилт 3.1.2 2019 онд нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар 10 хувь нь авч байсныг 2025 онд 90 хувиар нэмэгдүүлнэ.**

3.1.2.1 Нийгмийн халамжийн үйлчилгээ авагч иргэдийг нэрийн дансжуулж, цахим карттай холбоно.

3.1.2.2 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан иргэдийн 70 хувийг цахимаар үйлчилгээ авдаг болгоно.

### Орлогод нийцсэн орон байр

Зорилго 3.2 Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн орон сууц 2020 онд 108 өрх хангаснаас 2025 онд 256 өрхийг нэмж хангана.

**Зорилт 3.2.1 Орон сууцжуулах бодлогыг хэрэгжүүлнэ.**

3.2.1.1 Аймгийн төвийн "Түмний хороолол", "Хаус хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө", ажлын зургийг батлуулна.

3.2.2. Сумдад орон сууцны газар олгон барилга байгууламжийг ашиглалтад оруулна

### Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес

Зорилго 3.3 2019 оны Хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 2025 он хүртэл 2 хувиар нэмэгдүүлнэ.

**Зорилт 3.3.1 2019 оны ажиллаж байгаа 22040 иргэний байнгын ажлын байрыг 660-аар нэмэгдүүлнэ.**

3.3.1.1 Иргэдийг хөтөлбөр арга хэмжээнд хамруулж 199 шинэ ажлын байр бий болгоно.

3.3.1.2 Бүртгэлтэй ажил хайж байгаа иргэдээс сул чөлөөтэй байнгын ажлын байранд 201 иргэнийг нэмж зуучилна.

3.3.1.3 Хөдөлмөр эрхлэх төсөлд 260 иргэнийг нэмж хамруулан, байнгын ажлын байртай болгоно.

## Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

Зорилго. 3.4 Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас А, В үнэлгээтэй иргэд 2019 онд 21.9 хувьтай байсныг 2025 онд 36.9 хувьд хүргэнэ.

**Зорилт 3.4.1 Нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчид 2019 онд 25193 байсныг 2025 онд 28833-д хүргэнэ.**

3.4.1.1 Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэгчдийн хүрээг өргөжүүлнэ.

3.4.1.2 Спортын холбоод болон спорт хамтлагуудын үйл ажиллагааг дэмжиж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.

3.4.1.3 Аймгийн Цэнгэлдэх хүрээлэнг ашиглалтад оруулан, спортын талбайг байгуулна.

3.4.1.4 Олон улсын стандартад нийцсэн усан бассейн бүхий спортын цогцолбор байгуулна.

3.4.1.5 Сагсан бөмбөгийн 3x3 спортын төрлийг орон нутагт дэмжин хөгжүүлнэ.

3.4.1.6 "Бага олимп" наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.

**Зорилт 3.4.2 Ахмад настнуудын урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношлогоонд хамрагдалт 2019 онд 37.2 хувь байгааг 2025 онд 70 -аас дээш хувьд хүргэнэ.**

3.4.2.1 Ахмадад ээлтэй сум, баг, байгууллагыг журмын дагуу шалгаруулна.

3.4.2.2 Ахмад настнуудыг нас,бие бялдрынх нь онцлогт тохирсон алхалт, дасгал хөдөлгөөнд хамруулна.

3.4.2.3 Ахмад настнуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлж, ахмадын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

## Газрын харилцаа

Зорилго.3.5 Орон нутгийн геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зургаас 2020 онд 3 масштабын байр зүйн зургийг ашигладаг байсан бол 2025 онд 4 масштабын байр зүйн зургаар бүрэн хангана.

**Зорилт 3.5.1 1:25000 нарийвчлал бүхий шинээр боловсруулагдсан зураг зүйг үйл ажиллагаанд нэвтрүүлэн хүлээн авна.**

3.5.1.1 Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарт 2019 онд 1:100000 зураг зүйг ашигладаг байсныг 2025 онд 1:25000 нарийвчлал бүхий шинээр боловсруулагдсан зураг зүйг 2025 онд үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

## **ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ**

**Зорилго 4.** Аймгийн ДНБ 2019 онд 383383.01 сая төгрөг байгааг 2025 онд 545572.9 сая төгрөгт хүргэнэ.

### **Чинээлэг монгол**

Зорилго 4.1 Аймгийн үйлдвэрлэлийн салбарын ДНБ 2019 онд 71849.01 сая төгрөг байгааг 2025 онд 121758 сая төгрөгт хүргэнэ.

**Зорилт 4.1.1 "Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, жижиг дунд, хөнгөн, хүнсний үйлдвэрийн тоо 2020 онд 47 байгааг 2025 онд 57 болгоно. "**

4.1.1.1 Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурласан байгальд ээлтэй барилгын материалын үйлдвэрийг барьж ашиглалтад оруулна.

4.1.1.2 Аймгийн нийт хүн амын хүнсний хэрэгцээний 65 хүртэл хувийг орон нутагт үйлдвэрлэсэн эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр жигд хүртээмжтэй хангана.

4.1.1.3 Эдийн засгийн үр ашиг бүхий ажлын байр шинээр бий болгох инновацид суурилсан жижиг дунд үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжинэ

4.1.1.4 Барьцаа хөрөнгө дутагдалтай жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ

4.1.1.5 Жил бүр зохион байгуулагдах ДУНДГОВЬ-ТҮНШЛЭЛ үзэсгэлэн худалдаанд зориулсан зөөвөрлөгддөг павилонтой болно

4.1.1.6 "Дундговь үйлдвэрлэл" зорилтот санаачилга гарган хэрэгжүүлж Орон нутгийн онцлогтой брэнд бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд гаргах нутгийн иргэдийн өргөн оролцоотой хоршоодыг сум болгонд байгуулахыг дэмжинэ.

### **Уул уурхай, эрчим хүч**

Зорилго 4.2 Уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбарын ДНБ 2019 онд 647.5 сая төгрөг байгааг 2025 онд 3.148.0 сая төгрөгт хүргэнэ.

**Зорилт 4.2.1** Аймаг, сумтай хамтран ажиллах 3 талт гэрээтэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж 2020 онд 2 байсныг 2024 онд 18 болгон хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.2.1.1 Гурвансайхан сумын Хөтөл цагааны гантигийн ордыг түшиглэн чулууны үйлдвэр байгуулахад хамтран ажиллана.

4.2.1.2 Дэлгэрхангай сумын Тарагтын гөлтгөнийн уурхайг түшиглэн гипсэн хавтангийн үйлдвэр байгуулна.

4.2.1.3 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулна.

4.2.1.4 Салхитын мөнгөний ордыг ашиглахад орон нутгийн зүгээс дэмжиж, ордын тодорхой хувийг орон нутагт эзэмших асуудлыг Засгийн газар, Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлнэ.

4.2.1.5 Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, "Дундговь аймгийн хөгжлийг дэмжих сан" байгуулна.

**4.2.2 Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, дэд бүтэц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр хангана.**

4.2.2.1 Аймгийн төвийн 0,4кв-ын хуваарилах сүлжээг 100 хувь шинэчлэх, хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тоолуурыг ухаалаг тоолуураар сольж ашиглалтад оруулна.

4.2.2.2 Шаардлагатай сумдад усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглалтад оруулна.

4.2.2.3 Аймгийн төвийн дулааны станцыг барина.

4.2.2.4 Аймгийн төвийн шинэ суурьшлын бүс болон шаардлагатай сумдын төвийн цахилгааны хангамжийг сайжруулах ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ.

4.2.2.5 Аймгийн төвд шинээр баригдах дулааны станцын цахилгаан эх үүсгэвэр холбох 220/110/35кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажлыг ашиглалтад оруулна.

4.2.2.6 Эрчим хүч хэмнэх бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажлуудын хөрөнгийг шийдвэрлэнэ. /6, 7, 8, 15, 18-р байрны фасад/

4.2.2.7 Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлнэ.

**Бүс нутгийн хамтын ажиллагаа /Гадаад харилцаа /**

**Зорилго 4.3 Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хөрш орнуудтай салбар бүрийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.**



**Зорилт 4.3.1 Гадаадын улс орнуудтай бүхий л салбарт хамтран ажиллаж, хамтын ажиллагааны түвшинг 2020 оноос 5 хувиар нэмэгдүүлнэ.**

4.3.1.1 Турк улс болон ОУ-ын төслийн байгууллагуудтай, Мал аж ахуй, ЖДҮ, түншлэлийн харилцааг хөгжүүлэн, харилцан ашигтай хамтран ажиллана.

4.3.1.2 Канад улсын Засгийн газрын дэмжлэгтэй Мерит төслийн хүрээнд Институтын өөрчлөлт хийх замаар эрдэс баялагийн салбарыг сайжруулах, Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3.1.3 "Дэлхийн зөн" олон улсын байгууллагын гамшигт тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд иргэдийн амьжиргаа, даван туулах чадавхыг бэхжүүлэх замаар орон нутагт тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэлийг үе шаттайгаар бууруулна.

4.3.1.4 Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлага" хөтөлбөрийн хүрээнд инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийн шинэ санаа, санаачлагад дэмжлэг үзүүлнэ.

### **ТАВ. ЗАСАГЛАЛ**

**Зорилго 5. Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамж 2019 онд 65.8 хувьтай байгааг 2025 онд 81,8 хувьтай болгож нэмэгдүүлнэ.**

#### **Ухаалаг засаглал**

*Зорилго 5.1 Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулж, төрийн бодлого, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.*

**Зорилт 5.1.1 Ил тод байдлын аймгийн үнэлгээний үзүүлэлтийг 2019 онд 75 хувьтай байгааг 2025 онд 90 хувьд хүргэнэ.**

5.1.1.1 Төрийн үйлчилгээ үзүүлэх орчныг сайжруулж, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангана.

5.1.1.2 Иргэддээ ил тод, нээлттэй, хүнд сурталгүй шуурхай, чанартай, иргэндээ чиглэсэн үйлчилгээг нэвтрүүлж, нээлттэй төрийн үйлчилгээг бий болгох замаар " Иргэдтэй уулзах уулзалт, өдөрлөгийг зохион байгуулан иргэдээ сонсоно.

5.1.1.3 Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдож, иргэдэд үйлчлэх таатай орчныг бүрдүүлнэ.

#### **Ухаалаг бүтэц**

Зорилго 5.2 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, гадаад хамтын ажиллагааны нэгдмэл бодлогыг хэрэгжүүлнэ.

**Зорилт 5.2.1 Төрийн бус байгууллага, ААН- үүдийн хамтын ажиллагааг сайжруулж, түншлэлийн хэмжээнд хөгжүүлж, тэдний санал санаачилгыг дэмжиж ажиллана**

5.2.1.1 БНХАУ, Турк, ОХУ, БНСУ, Япон болон бусад улстай гадаад хамтын ажиллагааны хүрээнд тусгасан ажлуудыг шат дараалалтайгаар зохион байгуулна.

5.2.1.2 Төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор Гадаад улсад туршлага судлах сургалт арга хэмжээнд хамруулна

### **Цахим төр-Ухаалаг Дундговь**

Зорилго 5.3 Дижитал шилжилт хийх замаар төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн цахим мэдээллийн солилцоо, эргэх холбооны чадавхийг 2020 онд 10 хувьтай байгааг 2025 онд 90 хувьд хүргэнэ.

**Зорилт 5.3.1 Цахим технологид суурилсан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд шилжиж, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөл бүрдүүлнэ.**

5.3.1.1 "Цахим төр- Ухаалаг Дундговь" цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ

5.3.1.2 Төрийн байгууллага хоорондын төлөвлөлт, тайлагнах үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлнэ.

5.3.1.3 Төрийн архивын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг 2020 онд 50 хувьтай байсныг 2025 онд 100 хувь болгон сайжруулна.

### **Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба**

Зорилго 5.4 Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлнэ.

**Зорилт 5.4.1 Нэн хэрэгцээтэй байгаа боловсон хүчний нөөц бүрдүүлэн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

5.4.1.1 Засгийн газар болон аймгийн захиалгаар дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийж, ажлын байрны захиалгатай уялдуулан мэргэжлээр нь томилон ажиллуулна.

5.4.1.2 Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулна.

5.4.1.3 Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж, тэргүүний ажиллагаатай төрийн албан хаагчдын арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, алдаршуулах ажлыг зохион байгуулна.

5.4.1.4 Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан нь хариуцсан салбар, байгууллага, нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавьж, төрийн албан хаагч "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг мөрдүүлнэ.

5.4.1.5 Сумдын төрийн албан хаагчдад бодлогын баримт бичиг боловсруулах, төлөвлөх, тайлагнах чиглэлээр чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулна.

5.4.1.6 Төрийн албан хаагчдад манлайллын ур чадвар, хандлага сэтгэлгээ төлөвшүүлэх сургалт зохион байгуулна.

### **Хүний эрхийг дээдэлсэн нийгэм**

Зорилго 5.5 Иргэдэд үзүүлэх хууль зүйн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, жил бүр нийт иргэдийн 10-аас доошгүй хувийг хууль зүйн тусламж, үйлчилгээ, сургалт, суртчилгаанд хамруулж эрхийг хамгаална.

**Зорилт 5.5.1 Хүний эрхийг хангахад төр, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлж, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

5.5.1.1 Иргэд, олон нийтэд чиглэсэн нэгдсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг жил бүр 3-аас доошгүй сумдад зохион байгуулна.

5.5.1.2 Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлнэ.

### **Авлигагүй засаглал**

Зорилго 5.6 Аймгийн Шударга байдлын үнэлгээ 2019 онд 69.8 хувьтай байсныг 2025 онд 78,5 хувьд хүргэж нэмэгдүүлнэ.

**Зорилт 5.6.1 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, бүх шатанд шударга ёсыг эрхэмлэсэн иргэд, олон нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.**

5.6.1.1 Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтийн оролцоотой хамтран хэрэгжүүлнэ.

5.6.1.2 Сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтан(ЭБАТ)-уудыг жил бүр чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулна.

### **ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ**

**Зорилго 6.** Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлнэ.

## **Эх байгаль анхдагч экосистем**

Зорилго 6.1 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2020 онд 27 хувь байсныг 2025 онд 34.4 хувьд хүргэж өргөжүүлнэ.

**Зорилт:6.1.1 Тусгай хамгаалалттай газар нутгийг 2020 онд 238 байсныг 244 болгож нэмэгдүүлнэ.**

6.1.1.1 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулна.

6.1.1.2 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулна.

6.1.1.3 Аймгийн хэмжээнд амьтан, ургамлын нарийвчилсан тооллогыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн нөөцийг тогтооно.

### **Байгалийн баялгийн үр өгөөж**

Зорилго 6.2. Доройтсон орчныг нөхөн сэргээж, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ 2020 онд 41 байсныг 2025 он 92 болгон нэмэгдүүлнэ.

**Зорилт 6.2.1 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувийг 2020 онд 8.3 байсныг 2025 онд 21.7 хувиар нэмэгдүүлнэ.**

6.2.1.1 Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 100 га-д хийлгэнэ.

6.2.1.2 Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 25 га-д хийлгэнэ.

**Зорилт 6.2.2 Ногоон байгууламжийн хэмжээ 2020 онд 369.4 га байгааг 2025 онд 414.4 га-д хүргэнэ.**

6.2.2.1 Төв зам дагуу ногоон байгууламжийг бий болгоно.

6.2.2.2 Аймгийн хэмжээнд 4 га талбайд ойн зурвас байгуулна.

**Зорилт 6.2.3 Зэрлэг амьтдын нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөцийг хамгаалах арга хэмжээний тоо 2020 онд 11 байсныг 2025 онд 42 болгож нэмэгдүүлнэ.**

6.2.3.1 Зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, био-техникийн арга хэмжээ авна.

6.2.3.2 Тарвага нутагшуулах ажлыг зохион байгуулна.

### **Үнэт баялаг ус**

**Зорилго 6.3. Сумдад хиймэл нуур байгуулах, говийг усжуулах төсөлд хамруулах ажлыг олон улсын байгууллага, улсын төсөв, хувийн хэвшил зэргээс хөрөнгө оруулалтыг бүрдүүлж, шаардлага хангасан үндны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг 2020 онд 26,5 байсныг 2025 онд 31 хувьд хүргэнэ.**

**Зорилт 6.3.1 Гадаргын усан хангамж 2020 онд 53 байсныг 2025 онд 175 болгон нэмэгдүүлж, хомсдлоос хамгаална.**

6.3.1.1 Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, орон нутгийн тусгай хамгаалалтад авч тэмдэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулна.

6.3.1.2 Булаг шанд, усыг түшиглэн хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулна.

6.3.1.3 Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулна.

### **Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил**

**Зорилго 6.4. Аймгийн төвд хог хаягдлыг ангилах ажлыг эхлүүлж, хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэрт 2025 он гэхэд нийт хог хаягдлын 0.022 хувийг нийлүүлнэ.**

**Зорилт 6.4.1 Аймгийн төвд хог ангилан ялгах, дахин боловсруулах, булшлах шинэлэг арга технологийг нэвтрүүлж, хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэрт 2025 он гэхэд 70 тн дахивар хогийг нийлүүлнэ.**

6.4.1.1 Ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлнэ.

6.4.1.2 Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, эрүүлжүүлнэ.

6.4.1.3 Агаар, орчны бохирдлыг тодорхойлогч нарийн тоног төхөөрөмж бүхий автомат станцтай болж, түгээмэл тархацтай бохирдуулагч бодис /Азотын давхар исэл, хүхэрлэг хий, нүүрстөрөгчийн дутуу исэл, озон, РМ 2.5, РМ 10/-ыг хэмжиж агаарын чанарын индексээр үнэлнэ.

6.4.1.4 Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд шинэ дэвшилтэд техник, технологи /шахмал түлшний үйлдвэр/ нэвтрүүлэх аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.

**Зорилго 6.5 Цаг уурын ажиглалтын сүлжээг өргөтгөх, автомат станцын тоо 2019 онд 7 байсныг 2025 онд 11 болгоно.**

**Зорилт 6.5.1 Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, мэдээний таарцыг 2019 онд 93,4 хувь байсныг 2025 онд 96.1-д хүргэнэ.**

6.5.1.1 Урьдчилан мэдээлэхийн инженерүүдийг чадавхжуулна.

6.5.1.2 Цаг агаарын мэдээ зохиоход ашиглах зураг, загваруудын тоог нэмэгдүүлнэ.

6.5.1.3 Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

### **ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ**

**Зорилго 7. Гамшгийн эсрдэлийг бууруулж, иргэдийн амар тайван, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 2019 онд 67 байгааг 10 хувиар бууруулна.**

#### **Батлан хамгаалах**

Зорилго 7.1 Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт сурталчлан таниуулж, түүнд хяналт тавих, иргэд аж ахуйн нэгж байгууллагыг томилгоожуулна.

**Зорилт: 7.1.1 Орон нутагт батлан хамгаалах чадавхыг 60-иас доошгүй хувьд бэхжүүлж, батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн биелэлтийг хангах ажлыг тайван болон онцгой нөхцөлийн үед зохион байгуулж хэрэгжүүлнэ.**

7.1.1.1. Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуулийг 2 жил тутамд 1 удаа зохион байгуулна.

7.1.1.2 Цэрэг татлагаас эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн иргэдийг ээлжит татлагын хооронд эрүүлжүүлэх ажлыг шат дараалалтайгаар зохион байгуулна.

#### **Хүн, нийгмийн амар тайван байдал**

Зорилго 7.2 Гамшгийн эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чадавхийг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван амьдрах орчныг сайжруулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг 2020 онд 60 хувьтай байсныг 2025 онд 73 хувьд хүргэж бүрдүүлнэ.

**Зорилт: 7.2.1 Гамшгийн эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, чадавхыг бэхжүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.**

7.2.1.1 Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг малчид, иргэдэд шуурхай дамжуулах техникийн бэлэн байдлыг хангана.

7.2.1.2 Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг орон нутгийн нийт хүн амын 30 хувийг хамруулсан байна.

7.2.1.3 Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, жил бүр 6-аас доошгүй суманд сургууль үзлэг зохион байгуулна.

7.2.1.4 Шаардлагатай суманд Эрэн хайх, аврах бүлгийг байгуулж, үйл ажиллагааг зохион байгуулах хүч хэрэгслээр хангана.

7.2.1.5 Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор “Мазаалай” зорилтот санаачилга боловсруулж хэрэгжүүлнэ.

**Зорилт 7.2.2 Аймгийн хэмжээнд гэмт хэргийн гаралт 2019 онд 211 байсныг 2025 онд 10 -аас доошгүй хувиар бууруулж, түүнээс үүдэх хор уршгийг багасгана**

7.2.2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага, иргэд, олон нийтийн оролцоотой жил бүр бодитой төлөвлөж, хамтран зохион байгуулна.

7.2.2.2 Иргэний нийгмийн байгууллагатай хамтран архидан согтуурахтай тэмцэх орон нутгийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

7.2.2.3 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

7.2.2.4 Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлого, үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлнэ.

7.2.2.5 Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд, иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачилгыг өрнүүлж, дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

### **Хууль сахиулах салбарын хөгжил**

Зорилго 7.3 Хууль сахиулах байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны үр дүнг сайжруулж, гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувийг 2019 онд 86.5 байсныг 2025 онд 90-ээс дээш хувьд хүргэнэ.

**Зорилт: 7.3.1 Гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан хохирлыг барагдуулах бодит нөхцөлийг дээшлүүлж, 2019 онд 41.4 хувьтай байгааг 2025 онд 52-оос дээш хувьд хүргэж, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны үр дүнг сайжруулна.**

7.3.1.1 Аймгийн Шүүхийн барилгыг шинээр ашиглалтанд оруулж, алба хаагч, иргэдэд үйл ажиллагаа, үйлчилгээний ая тухтай орчин бүрдүүлнэ.

7.3.1.2 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд албан байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцлага, сонор сэрэмж, үүрэг оролцоог сайжруулж, томоохон гудамж талбай, сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлнэ.

7.3.1.3 Аймгийн Цагдаагийн газрын автопаркын болон алба хаагчдын 25-аас доошгүй хувийн хэт богино долгионы радио холбоог шинэчилж, албан хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.

7.3.1.4 Аймгийн Шүүхийн шинжилгээний албанд шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж бие даасан, хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлнэ.

7.3.1.5 Цагдаагийн байгууллагад иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээ нэвтрүүлнэ.

### **НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ**

**Зорилго 8.** Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, аялал жуулчлал, хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, хөдөө аж ахуйн гаралтай үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээг 2020 онд 277,76 байсныг 2025 онд 316,87 болгож нэмэгдүүлнэ.

#### **Дэд бүтэц**

*Зорилго 8.1. Эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр аймгийн тээвэр, мэдээлэл, холбооны салбарын ДНБ 2019 онд 5328.6 сая төгрөг байгааг 2025 онд 69 сая төгрөгөөр өсгөнө.*

**Зорилт 8.1.1. Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн тээвэр, дэд бүтцийн хүрээний ажлыг хэрэгжүүлнэ.**

8.1.1.1 Аймгийн төвд ачаа буулгах, хадгалах, шилжүүлэн ачих томоохон терминал ложистикийн төв байгуулна.

8.1.1.2 Сумдын ерөнхий төлөвлөгөөтэй болно.

8.1.1.3 Жишиг гудамж төсөл, тохижилтын ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ.

8.1.1.4 Иргэдийн оролцоотой "Шинэ сум" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэд бүтэцтэй сум 2020 онд 2 байсныг 2025 онд 3-аар нэмэгдүүлнэ.



8.1.1.5 Мандалговь-Улаанбаатар, Мандалговь-Даланзадгад чиглэлийн Улсын чанартай хатуу хучилттай авто замын арчилгаа, засварын ажилд хяналт тавьж, орон нутгийн авто замын засвар, арчилгааны хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ.

8.1.1.6 Цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад 2020 онд 27880 багц мессежээр дамжуулсныг 2025 онд 60000 багц мессежээр дамжуулдаг болгоно.

### **Аялал жуулчлал**

Зорилго 8.2. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн гадаад жуулчдын тоог 2019 онд 19540 байсныг 2025 онд 30000-д хүргэнэ.

**Зорилт 8.2.1 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой эвент арга хэмжээ 2019 онд 4 байсныг 2025 онд 13-аар нэмэгдүүлнэ.**

8.2.1.1 Жуулчдын голлон зорих байгаль, түүх, соёлын өв бүхий Дэл уул зэрэг газруудыг тохижуулж, эко ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгүүдийг байгуулна

8.2.1.2 Сүм хөх бүрд зэрэг аялал жуулчлалын гол бүс нутгуудад орон нутгийн өмчийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих замаар үйлчилгээний чанарын стандартыг дээшлүүлнэ.

8.2.1.3 Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр нэгдсэн зохион байгуулалттай оролцож, /хятад, солонгос, англи зэрэг хэл дээр видео контентууд хийж/ орон нутгаа сурталчилна.

### **Тогтвортой хөдөө аж ахуй**

